

## ХУРАЛДААНЫ ТОЙМ

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ АРВАНДӨРӨВДҮГЭЭР ХУРАЛДААН

Хуралдаан 2016 оны дөрөвдүгээр сарын 07-ны 14 цаг 05 минутад эхэлж, 15 цаг 05 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 48 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд нээлттэй зарлуулах тухай	Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогтын 2016 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 10-2/2236 тоот албан бичгээр Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалт зарлуулах захиалга ирүүлснийг хэлэлцээд, сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, 2016 оны 5 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэв
2	Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, өрийн удирдлагын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд нээлттэй зарлуулах тухай	Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Ганцогтын 2016 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 10-2/2236 тоот албан бичгээр Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, өрийн удирдлагын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалт зарлуулах захиалга ирүүлснийг хэлэлцээд, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, 2016 оны 5 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэв.
3	Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудаас төрийн захиргааны зарим албан хаагчид төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгуулах талаар ирүүлсэн саналын тухай	Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйл, “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг батлах тухай” Улсын Их Хурлын 1995 оны 73 дугаар тогтоолоор баталсан журмын 2, 6 дахь заалт, “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журамд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын 2000 оны 20 дугаар тогтоолын 1-д заасны дагуу төрийн захиргааны албан тушаалын тэргүүн болон эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгуулахаар ирүүлсэн

		<p>саналыг хэлэлцээд, таван албан хаагчид тэргүүн түшмэлийн, нэг албан хаагчид эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгуулах саналыг Засгийн газарт уламжлахаар шийдвэрлэв. Ажлын хэсэг Улсын Их Хурлын тогтоол, журамд заасан шаардлагын дагуу Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгуулахаар ирүүлсэн баримт бичгийг судалж үзэхэд эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгуулах 4 албан хаагч шаардлага хангаагүй тул буцаахаар тогтлоо.</p>
--	--	---

## **ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА**

